

ГЕРМАНЫ ЭРДЭМТЭД ТӨВ АЗИЙГ ХҮШ-XX ЗУУНД СУДАЛСАН НЬ

(Казахстан, Дорнод Туркестан, Монгол судлалын жишээн дээр)

*М.Хурметхан**

Эхлэл нь өмнөх дугаарт

1905 оны 12-р сард А.фон Ле Кок ба Т.Бартус нар Германаас дөнгөж ирээд байгаа А.Грюнведель болон хятад судлаач П.Порт нартай Кашгарт уулзжээ. Ийнхүү Төв Азийг судлах гурав дахь шинжилгээний ангийн ажил эхэлжээ. Уг ангийг профессор А.Грюнведель удирдаж, А.фон Ле Кок ба Т.Бартус, П. Порт /Н.Porth/ нар оролцжээ. Аялалын зам нь Кашгар-Тумшук (1906 оны 1-р сар)-Кизил-Куча-Кумтура (1906 оны 2-р сар)-Корла-Турфаны баянбүрд (1906 оны 7-р сар)- Урумчи -Хами-Туюк (1907 оны 1-р сар)-Шорчук (1907 оны 2.3-р сар)- Турфаны чиглэл байв. Буцах зам нь 1907 оны 4-р сард Урумчээр дайран өнгөрчээ. Судалгааны явцад 118 хайрцаг олдвор цуглуулсан байна. Эрдэмтэд Маралбашийн ойролцоо хүрэлцэн ирсэн бөгөөд өргөн хэмжээний малтлага хийхгүйгээр буддын сүмийн эвдэрхий балгасыг судалжээ. Дараа нь тэд Кумтурын рүү явж, Мин-уй буюу эртний буддын хийдүүдийн овооролдон багширсан газар луу зүглэжээ. Кумтурд амжилттай хийсэн судалгааны төгсгөлд сулаачид Кизилийн Мин-уйд, Кумтураас баруун тийш 25 км, Кизилаас хойшоо 8 км-т баазаа шилжүүлэн суурьшив. Жуулчид уулын замаар өгсөж даваанд гарахад тэдний нүдний өмнө гайхамшигт хөндий харагджээ. Энэ бол уулын нурууны хормойгоор цавчиж цоолон байгуулсан том барилга байгууламж болох Мин-уй - мянган агуй байсан бөгөөд тэр хүртэл тэнд европын ганц ч хүний мөр гараагүй байсан юм. Зөвхөн Японы нэрт эрдэмтэн Отаны Сесин л мөрөө гаргасан байлаа. Агуйн тоо бол зөвхөн гол хэсэгтээ гэхэд хэдэн зуугаар тоологдох болов ч зарим нь эвдэрч тэдгээрийн орох хаалга нь шороогоор нь булагджээ. А.Гренведель эдгээр агуйнуудын маш ойролцоо байрлал зургийг хийв. Тэрээр уулын гүвээний дээрээс алсаас агуйнуудын үзэгдэн харагдах зургийг зурахад их цаг хугацаагаа зарцуулсан ба тэнд Кизилийн Мин-уйн тоо тоомшгүй агуйнууд овоорсон байлаа. Агуйг судлахын тулд тэдгээрийг дүүрсэн элс болон уулын нурангаас цэвэрлэх шаардлагатай болов. Ийм нөхцөлд 2 сар хагасын дотор 20 илүү агуйн байгууламжийг нарийвчлан судалж, тодорхойлолт бичиж тэдгээрийн хэмжээ ноорог зураг зэргийг үйлдсэн байна. Тэрчлэн агуйн засал чимэглэл зэргийг фото зурагт буулган дүрсийг бэхжүүлэх, хуулбар зураг хийх зэрэг ажил хийжээ. Агуйн байгууламжид нь хэдэн арван бүр хэдэн

* М.Хурметхан - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

зуун хүмүүсийг дүрсэлсэн уран зургийг нарийн дүрсэлсэн зохиомжууд хадгалагджээ. Эдгээрийн нэг бүрийг судлахад судлаачдаас нөр их хөдөлмөр, домог зүй, бурхны хөрөг зургийн асар их мэдлэг шаардаж байсан юм. Ихээхэн хөлс асгаруулсан судалгааны үр дүнд Дорнод Туркестаны бурхны урлагийн хосгүй урлаг болох “Гиппохамын агуй”, “Уран зураачийн агуй”, “16 шидэт цэргийн агуй”, “Майейн агуй”, “Нагаражийн агуй”, “Хөгжимчдийн агуй” зэргийг бүрэн судлан тодорхойлжээ. Судалгааны эхний өдөр гэхэд агуй хийдийн нэгнээс эртний номын сангийн үлдэгдлийг олж илрүүлсэн нь “Улаан бөмбөгөр оройт агуй” нэртэй байв. Уг ном хадгалагдах газраас дал модны навч, хусны үйс болон цаасанд бичигдсэн, хавтаслагдсан номнууд олдсон ба тэдгээрээс 60 хуудастай нэг ном бүрэн бүтэн хадгалагдсан байжээ.

Эрдэмтэд Муртук дахь Безеклекийн агуйн хийдүүдийг судлах, тодорхойлолт бичихэд багагүй хүч хөдөлмөр зарцуулжээ. Эдгээр цогцолборын талаар өмнө нь Д.А.Клеменц судалж байсан бөгөөд А.Грюнведель анхны шинжилгээний ангийн судалгааны явцад очиж байсан боловч ганц сэдэвт судалгааны хэмжээнд зөвхөн 1906 оноос л судлах ажлаа эхэлжээ. Тэрчлэн Шорчук, Туях, Харахожа, Харашахрын болон бусад хотын туурийн дурсгалуудыг судалжээ.³³

Дорнод Туркестан дахь Германы 4-р шинжилгээний анги 1913 оны 3-р сараас 1914 оны 3 сар хүртэл судалгааны ажлыг явуулсан бөгөөд А.фон Ле Кок удирдаж, Т.Бартус техникийн ажлыг гүйцэтгэсэн байна. Эрдэм шинжилгээний хээрийн судалгааг бэлтгэх болон санхүүжүүлэх ажлыг Турфаны хороо удирдан гүйцэтгэсэн байна. Аялалын зам нь Кашгар-Хуча-Кизил-(1913 оны 6-9 сар)-Кириш-Симсим-Кумутур (1913 оны 11-р сар)-Тумшук (1913 оны 12 сараас 1914 оны 1-р сар хүртэл)-Кашгараар дайран өнгөрөв. Энэ удаагийн судалгааны явцад тус бүр нь 75-80 кг жинтэй 156 хайрцаг олдвор олсон нь голдуу Тумшукаас олсон сак, санскрит бичээс байлаа. Шинжилгээний анги Кашгараас Кучу руу зүглэн Тумшукт буудалжээ. Кизилийн ойролцоо мянган агуйд А.фон Ле Кок судалгаагаа үргэлжлүүлэн, урьд өмнө мэдэгдээгүй цогцолборуудыг шинээр илрүүлэн, Т.Бартус туурганы олон зургийг хананаас хуулан авсан байна.

Субаши хэмээх газар жуулчид томоохон хийд болон бэхлэлтийн балгастай дайралджээ. Энд өмнө нь П.Пеллогийн шинжилгээний анги судалгаа хийж байсан байна. Куча голын зүүн эрэгт байгаа хотын нурангитай танилцах бололцоо судлаачдад олдоогүй юм. Голын баруун эргийн хуучин балгасын төвд гишгүүр бүхий том хийд байсан бөгөөд өмнө нь францчууд малтлага хийсэн байжээ. А.фон Ле Кок хуучин балгасын хойт талаас агуйн хийцийн цогцолборыг илрүүлэн олсон бөгөөд түүний хаалга нь тахилын шавраар хээ угалз гарган чимэглэсэн чимэглэл, хөрөг дүрсийн үлдэгдэл зэрэг олджээ.

Хонгилд нэг зүйл харошти бичгийн бичээс, Энэтхэгийн брахмигаар бичсэн хэдэн үг олдсон байна. Тэндээс мөн хожмын Хань улсын үеийн зоос олджээ. Дараа нь А. фон Ле Кок Аджик-Илекын хавцалд малтлага хийжээ. Эндээс цайзаар хүрээлүүлсэн жижиг хотын туурийг илрүүлэн олжээ. Түүнээс баруун тийш мөн 4 хийдийн туурийг олсон бөгөөд малталтын явцад хана нь туургын зургаар чимэглэгдсэн нь тодорхой болжээ. Хавцлын аманд үзүүрт хаданд ухаж гаргасан хүнхгэр байгууламж олсон ба тэндээс энэтхэг бичгээр бичсэн хэд хэдэн гар бичмэл мөн олджээ. Дараа нь Симсимд газар дээрхи болон агуйн хийдүүдийг судлав. Тэдгээрийн хананд мөн нарийн дүрслэл, зохиомж бүхий туурганы зургууд байжээ.³⁴ Тэнд анхаарал татсан зургуудын нэг нь гартаа могой, амьтдыг барьсан бурхны хөрөг байсан нь өрнөдийн нөлөөг тусгасан байна. Кучагаас зүүн хойт талд 2 км-т германы судалгааны багийнхан Кум-Арыкын бурхны сүмийн туурийг судалсан байна. Эртний сүмийн эвдэрхий газрын хөрснөөс доош байсан ба хамгийн сонирхолтой нь балгаст найман өнцөгт уур, лалын мечеть-Минг-жен-Ата байжээ.

Кумтурд А. фон Ле Кок Музарт голын урсгалын дагуух хийдийн цогцолборыг судалсан байна. Хавцлын хаданд ухаж хийсэн үндсэн агуйнуудад хүрч, бурхны чулуун баримлын үлдэгдлийн хэмжээг тодорхойлон, хаданд брахмигаар бичсэн бичээсийн эстампжийг хийжээ. Бурхны баримлын чулуун араг бие нь Бамианд байсан бурхны аварга баримлыг хийсэн арга технологитой адил байжээ. Эрдэмтэн эндэхийн туургын зурагт хятадын нөлөө байгааг тэмдэглэжээ. Музартын хүн оршин сууж байсан нэгэн агуйгаас хятад ба түрэг руни бичээсийн дурсгалыг илрүүлэн олжээ. А.фон Ле Кок нь түрэг руни бичээс нь IX зуунаас хойшхи үед хамаарх юм гэж үзжээ. Шинжилгээний ажлын төгсгөлд Тумшукт хийсэн малталтаар мөн олон тооны үнэт дурсгалыг илрүүлэн олсон түүхтэй билээ.

Германы эрдэмтдийн Дорнод Туркестанд явуулсан дөрвөн удаагийн экспедицийн үр дүнд материаллаг соёл, бичиг үсэг, урлагийн олон тооны дурсгалыг авч иржээ. Тэдний газар дээр судалсан байгаль, хүн ам болон архитектур, урлагийн тодорхой судалгаа, археологийн олдворын товч тодорхойлолт зэрэг нь шинжлэх ухааны хувьд үнэлж баршгүй үнэ цэнэтэй хэвээр байна. А.Грюнвелел, А. фон Ле Кок өөрсдийн ажиглалт болон цуглуулгын материалаа боловсруулан томоохон судалгааны бүтээлийн цувралыг хэвлүүлсэн юм. Турфаны шинжилгээний ангийн анхны баримтжуулалт нь ХБНГУ-д хадгалагдаж байна. Өнгөрсөн хугацаанд Турфан судлалын ажиллагаа үргэлжилж, тэдгээр судалгааны явцад дөрвөн удаагийн экспедицээр цуглуулсан 20 хэл, бичгээр бичигдсэн 400000 бичиг, тасархай зэргийг судлах ажиллагаа үргэлжилж байна.³⁵

XIX зууны эцэст Европын жуулчид болон эрдэмтдийн Төв Азид хийсэн нээлтүүд нь Германы өмнө нь судлагдаж тайлагдаагүй соёл иргэншлийг судлах сонирхлыг төрүүлсэн байна. Герман улс Турфанд өөрсдийнхөө бие даасан шинжилгээний багийг бэлтгэн явуулах асуудлыг 1899 онд Рим хотод хуралдсан дорно дахин судлаачдын XII их хуралд Төв Азид олдсон олдворын тухай шуугиан тарьсан илтгэлүүдийн дараа удалгүй шийдвэрлэжээ.

1902 оны 12-р сарын эхээр Дорнод Туркестанд хүрэлцэн ирсэн профессор Альберт Грюнведель ахлагчтай бүрэлдэхүүнд дорно дахинч Георг Хат, музейн техник ажилтан Теодор Бартус нар орсон экспедицийг 40000 маркаар санхүүжүүлсэн байна. Дараагийн гурван удаагийн экспедицийг улсаас санхүүжүүлжээ. Хоёр ба гуравдугаар экспедицийн ажлын дүн А.Грюнведелийн "Altbuddhistische Kultstätten in Chinesisch-Turkistan" (1912) болон A. Le Coq. Auf Hellas Spuren in Ostturistan. Berichte und Abenteuer der II. Und III. Deutschen Turfan-Expedition, Leipzig 1926., A short account of the origin journey and results of the first Royal Prussian /second German/. expedition to Turfan in Chinese Turkistan, JRAS 4 /1909/ Türkische Manichäica aus Chotscho, Bd. 1-3. Berlin 1912-1922. зэрэг бүтээлүүдэд хэвлэгдсэн бол Дөрөв дэх удаагийн хээрийн судалгааны дүн нь А. фон Ле Кокийн "Von Land und Leuten in Ostturkistan. Berichte und Abenteuer der IV Deutschen Turfanexpedition.", Leipzig 1928 гэсэн бүтээлд оржээ.

Нээлтийн гол тодорхойлолтууд нь Ле Кокийн "Chotscho" (1913), "Bilderatlas zur Kunts und Kulturgeschichte Mittelasiens" (1925), "Die Buddhistische Spätantike in Mittelasien" (1922-1933) гэсэн 1-5 ботиуудад болон Эрнст Владимиртэй хамтран бичсэн 6-7 ботид тусгагджээ.

Германы Турфаны шинжилгээний багийн олсон олдворууд нь анхлан угсаатны зүйн музейн Энэтхэгийн хэлтэст, дараа нь 1963 онд Энэтхэгийн урлагийн музей (Museum für Indische Kunst) байгуулагдахад түүнд байрлуулжээ. 1914 онд бүх гар бичмэлийг Konglish-Preubische-Akademie der Wissenschaften-д шинжлүүлсэн байна. Дорно дахины хороо (Orientalische Kommission) германы шинжилгээний ангийн цуглуулсан материалыг судлах ажлыг зохион байгуулж байв. Дэлхийн хоёрдугаар дайн хүртэл дорнодахины олон салбараар нэрт эрдэмтэд оролцсон судалгааны олон бүтээл хэвлэн нийтэлж байв. Дэлхийн хоёрдугаар дайны үед Турфаны цуглуулга нь Винтершалл, Солвейтхалле болон Эльбе дэх Шоннебекийн давсны уурхайд хадгалсан байжээ. Турфаны цуглуулгын бүрэн бүртгэл байгаагүй тул дайны үед алдагдсан бичээсийн тухай мэдэх боломжгүй ажээ.

1946 оноос Турфаны цуглуулга янз бүрийн газар, байгууллагад хадгалагдаж байснаа 1992 онд бүгдийг нь Берлины Бранденбургийн

байгалийн болон нийгмийн шинжлэх ухааны академи /Berlin-Brandenburgische Akademie der Wissenschaften, BBAW/-д төвлөрүүлсэн юм.

Дайны дараа Турфаны цуглуулгын бичээсийг судлахад тэдгээрийн хуваагдсан явдал бэрхшээл учруулж байжээ. Санскрит хэл дээр байгаа хэсгийг нилээд судлан нийтэлсэн бөгөөд перс болон уйгур хэлний материалыг судлах ажил үргэлжилсээр байгаа юм. Эдгээр бичээсийн цэсийн жагсаалтыг “Turfanforschung” төслийн ажилтнууд эрхэлж байгаа юм. Мөн Турфаны цуглуулгыг сэргээн засварлаж, дижитал хэлбэрт оруулан нийтийн хүртээл болгожээ.

Германы шинжилгээний ангийн ажил эхэлсний 100 жилийн ойд зориулсан олон улсын бара хурал “Turfan Revisited The First Century of Research in to the Arts and Cultures of the Silk Road” нэртэйгээр Берлин хотноо болжээ. “Monographien zur Indischen Archäologie, Kunstgeschichte und Philologie” цувралаар уг бага хурлын материалуудыг Эрнст Вальдшмидтын сангаас эрхлэн 17 ботиор 2004 онд хэвлүүлсэн юм.

Үүнээс дараах германы хоёр удаагийн экспедиц нь шинжлэх ухааны түүхэнд хавьгүй бага ач холбогдолтой болжээ. Төвд судлаач О.Франке /O.Franke/ 1914 онд Яркенд болон Хотанд судалгаа явуулжээ. Түүний цуглуулсан хэсэг нь Мюнхений угсаатны зүйн музейд байгаа бөгөөд хэвлэгдээгүй үлджээ. О.Франке нь Дорнод Туркестанаас түмэн наанги шороо болон баримал, модон эдлэл, хятад, кушан, харошти, араб зоос зэргийг авч иржээ. Уг эрдэмтэн араб, согд, хятад бичгийн 350 хэсгийг олсон байна.

1927-1928 онд газар зүйч Э.Тринклер /Trinkler .E/-ийн /1896-1931/ удирдлагаар Төв Азид судалгааны эспедиц ажиллажээ. Бүрэлдэхүүнд нь нэрт геологич Г.де Терра /Terra.H.de/, фото зурагчин ба кино оператор В.Босхард /W.Bosshard/ нар оржээ. Судалгааг Берлиний судалгааны байгууллага ба Бремений сенат зохион байгуулжээ. Э.Тринклер, В.Босхард нар Кашгараас Хотан руу чиглэн замдаа архитектур болон археологийн дурсгалуудыг зургийн хальсанд буулгажээ. Хотанаас Аксипилд ирж бага зэргийн малтлагын ажил хийжээ. Мөн хэд хэдэн газар малтлагын ажил хийж, олон тооны эртний зүйлс, гар бичмэл зэргийг худалдан авчээ.³⁶ Археологийн материалуудыг Бремений музейд, гар бичмэлүүдийг Пруссийн Академид өгсөн байна. Үүнээс хойш 25 жил өнгөрсний дараа эдгээр материалыг Г.Гропп /G.Gropp/ нарийвчлан судлан хэвлүүлжээ.³⁷

Мөн Төв Азийн судлалд Германы эрдэмтэд Маркверт Йозеф /1864-1930/,³⁸ А фон Габен /Annemarie von Gabain/,³⁹ Ф.В.К.Мюллер,⁴⁰ В.Банг, И.Бенфинг,⁴¹ Г.Деффер⁴² нарын эрдэмтэд хүннү хэл, утга зохиол зэргийг судлан дорно дахины судлалд жинтэй хувь нэмэр оруулжээ. Энэ бүхнээс дүгнэн үзэхэд Германы Төв Азийн

судлал нь тус бүс нутгийн өнгөрсөн түүх, материаллаг ба оюуны соёл, уугуул угсаатнуудыг танин мэдэх нэгэн чухал тулгуур юм. Марк Киршнер, Томас Хоппе нар Дорнод Туркестаны казахуудын өнгөрсөн зууны үеийн зарим асуудлыг судалсан байна.⁴³ Орчин үед ч гэсэн Германы эрдэмтэд энэхүү уламжлалыг үргэлжлүүлэн, Төв Ази судлалд хүндтэй байр эзэлж байна.

Германд Монгол судлал хөгжсөн нь

Германд Монгол судлал ХУИИ зуунаас үүсвэрлэн ХХ зууны дунд үе хүртэл Орос, Хятад судлалын дагалдах салбар байснаа бие даан хөгжих болжээ. Монгол судлалын анхны бүтээлүүдийг түрэг, хятад судлалын эрдэмтэд бүтээжээ. Тухайлбал, 1837 онд Эрлман “Халимаг Жангар” гэдэг өгүүлэгийг, түүний дараа 1863 онд Габелени “Хятад, Монголын чулууны бичээс” гэдэг өгүүлэл нийтлүүлжээ. Эдгээрийг Францад монгол судлалын анхны бүтээл 1710 онд, Англид 1722 онд нийтлэгдэж байсныг бодвол хожуу эхлэлтэй юм. Герман улсад монголын аман ба бичгийн дурсгалыг судлах нь их уламжлалтай бөгөөд энэ салбарт эрдэм шинжилгээний хамгийн нарийн арга зүй төлөвшсөн байдаг.

Их Петер хааны болон түүний дараах үеийнхний Орос оронд ажиллаж байсан Герман гаралтай эрдэмтэд судлаачдын ном бүтээл, түүнчлэн ХУИИ зууны эцэс, ХІХ зууны эхэн үеийн Оросын эрдэмтдийн судалгаа нь Германд Монгол судлалыг судлах сонирхлыг өдөөж өгсөн байна.

ХУИИ зууны дунд үед Оросын эзэнт улсын албанд ажиллаж байсан Готтлоб Шобер (1670-1739), Даниел Готтлеб Мессершмитд (1685-1735), И.Фишер (1697-1771), Герхард Фридрих Мюллер (1705-1783), Петер Симон Паллас (1741-1811), Исаак Якоб Шмитд (1779-1847), Ёоканнес Йэйриг (1795 онд нас барсан), Юлиус Фон Клапрот (1783-1835) зэрэг хүмүүс монголчууд, түүний дотор халимагуудын тухай аян замын тэмдэглэлдээ дурдан бичиж байсан нь Герман улсын эрдэмтэд түүний дотор Август Лүдвик Шлецер (1735-1809) зэрэг олон хүмүүсийн сонирхлыг татаж байжээ.

Монгол хэл түүхийг судлахад Оросын халимагуудын дунд шашин номлохоор ирээд байсан Германы Ё.Йэйриг, И.Я.Шмидт нар шийдвэрлэх үүрэг гүйцэтгэжээ. Ё.Йэйриг “Оросын хааны академийн дэргэдэх олон монгол хэлний орчуулагч” гэж нэрлэгдэн 1776-1801 онд Петербургт хэвлэгдэн гарсан “Монгол угсаатны тухай түүхийн мэдээний цуглуулга” номын монголчууд ба халимагуудын мэдээллийн ихэнх хувь нь монгол зохиолын орчуулгын хамт түүний бүтээл байжээ. Түүний цуглуулан Германы Геттинген хотын их сургуульд бэлэглэсэн Монгол, халимаг хэл дээр 33 гар бичмэл Герман улсад орж ирсэн энэ төрлийн материалын анхных нь агаад монгол судлалын эх сурвалж бүрдэх цөм нь болсон байна.

И.Я.Шмидт (Prof. Schimidt Isaak Jakob 1779-1847) нь Орос байхдаа монгол хэлийг эрчимтэй шинжлэн судалж, хамгийн анхны “Монгол хэлний хэл зүй” (Петербург 1831) мөн анхны “Монгол-Герман-Орос хэлний толь” (Петербург, 1835) толийг зохиосон гавьяатай эрдэмтэн билээ.⁴⁴ Тэрбээр бүр 1829 онд Саган цэцэний монгол түүхийн номыг орчуулан хэвлүүлсэн зэрэг нь Герман хэлтний дунд монголын утга зохиолыг сонирхож түүний хэл зүй, толь бичгийн ачаар монгол судлалыг хөгжүүлэх боломжийг бүрдүүлэн өгчээ. Ийм учраас Ё.Йэрийг, И.Я.Шмидт нарыг монгол судлалын оюун ухааны эцэг хэмээн зүй ёсоор нэрлэдэг байна.

1813 оноос Хайнрих Август Цвик “Халимаг хэлний зүй” (1851), “Халимаг хэлний толь бичиг” (1853) зохиосны зэрэгцээ уг хэлээр бичигдсэн маш олон тооны гар бичмэл цуглуулсан нь Германы Саксони мужийн номын сан дахь цуглуулгын гол цөмийг бүрдүүлсэн байна. Төв Азийн олон хэлийг Берлиний их сургууль дээр Вилхелм Шотт (1807-1889) сонирхон судалж, алтай судлалын сэдвээр хамгийн анхны өгүүллүүдийг бичиж, Урал алтайн хэл шинжлэлийн үндсийг тавилшжээ.

XIX зууны эхний хагаст Германы Баденаас гаралтай доктор профессор Бернхард Юлг (Prof. Julg Bernhard 1825-1886) анх Монгол судлалаар дагнан, Оросын тухайн үеийн нэрт Дорно дахин судлаачтай түүний дотор Ханс Конон Фон Дер Габеленц (1807-1874)-тэй харилцан санал бодлоо солилцдог байсан нь түүнийг 1861-1868 онд Лейпциг болон Инсбрукт хэвлүүлсэн “Шидэт хүүрийн үлгэр”, “Аржи Боржи” зохиолын монгол хувилбарын тухай эрдэм шинжилгээний бүтээлээ туурвихад хүчтэй нөлөө үзүүлжээ.⁴⁵

Доктор Бертолд Лауфер (Dr. Laufer-Bertold 1874-1834) бол хятад, япон, манж, монгол, малайз, санскрит, перс, семит хэлний судлаач байлаа. Номхон далай, Сахалин, Амур мөрнөөр аялсан нь маш их үр дүнтэй болжээ. 1908-1910 онд Чикаго хотын түүхийн музей “Блейкстоун” шинжилгээний ангийг удирдан Төвд, Хятад руу аялжээ. 1923 онд доктор Бертолд Лауфер Маршалын хээрийн шинжилгээний ангийн удирдагчаар ажилласан музейн гарамгай мэргэжилтний хувьд тэрээр судалгааны ганц сэдэвт зохиол, өгүүлэл 150 орчмыг туурвисан бөгөөд түүнээс 37 нь монгол, манж, уйгар, алтайн хэл шинжлэлтэй холбоотой юм.⁴⁶

Доктор профессор Вилхелм Александр Ункриг (Unikrig, Wilhelm-Alexander) (1883-1956) нь монгол судлаач юм. 1908 онд Оросын Казан хотын шашны академид суралцан, монголын шашин номлогчийн боловсрол эзэмшсэн байна. Тэр монгол, төвдийн гар бичмэл болон модон барын номыг голчлон судалжээ. Монгол-Төвдийн анагаах ухааны талаар судлан зарим бүтээлийг герман хэлэнд орчуулсан байна. Түүний бүтээлийн жагсаалтанд монгол судлалын 70 орчим бүтээл тэмдэглэгджээ.⁴⁷

XX зууны эхээр Герман улсад ажиллаж байсан монгол судлалын эрдэмтэд судалгааны ажлаа идэвхтэй үргэлжлүүлж байжээ. Германд улс орны шинжлэх ухааны судалгааны ажлыг зохицуулан чиглүүлэгч төр-олон нийтийн төв байгууллага болох Германы эрдэм шинжилгээний нийгэмлэгийн дэргэдэх “Төлөвлөлтийн бүлэг” дорнодахины судлалын хэрэгцээг тусгайлан судлаад 1960-аад онд “Дорнодахины судлалын меморандум”-ыг нийтлэн гаргажээ. Түүнд Азийг судлах ажлыг эрчимжүүлэх, энэ зорилгод зориулах холбооны болон муж улсын зардлыг нэмэгдүүлэх, шинэ шинэ судалгааны төвүүдийг байгуулах, эрдэм шинжилгээний тухайлсан хөтөлбөрүүдийг боловсруулахад их үүрэг гүйцэтгэсэн байна. Анх 1958 онд Бонны их сургуулийн Дорнодахины судлалын Семинарын эрхлэгч Отто Шпиисийн идэвхи санаачлагаар мөн тэр үед Геттингенээс томилогдсон В.Хайссигийн удирдлагаар монгол судлалын салбар байгуулагдаж, улмаар 1964 онд Төв Азийн хэл, соёл судлалын семинар нэртэйгээр өргөжсөн байна. Семинарын захирал В.Хайссиг хүчин чармайлт гаргаж сургалт, судалгааны тулгуур материал болох гар бичмэлүүдийг дэлхийн олон хотын номын сангаас хуулбарлан авч, номын сандаа төвлөрүүлж чадсан байна. XX зууны 60-70 онд тус семинарт голдуу өрнөдийн орнуудын монгол судлаачид уригдан ажиллаж, сургалт явуулан, номын санд ажилладаг байв.

70-аад оны дундаас Төв Азийн семинарын гадаад харилцаа өргөжиж, БНМАУ, ЗХУ, БНХАУ-аас оюутан суралцан, эрдэмтдийн солилцоо өргөжсөн байна.

1969 онд Германы судалгааны нийгэмлэгийн (Deutsche Forschungsgemeinschaft) дэмжлэгтэйгээр “Дорнодахиныг судлахдаа Төв Азийн онцлогийг анхаарах” нэртэй тусгай судалгааны салбарын хүрээнд тус семинарын эрдэмтэн судлаачид доктор В.Хайссигийн удирдлагаар 12 жил (нийт 19 жил) Төв Азийн олон асуудлыг бие даасан төслүүдээр шинжлэн судлаж, үр дүнгээ 1967 онд В.Хайссигийн үндэслэсэн “Төв Азийн судлал” цуврал сэтгүүлд нийтэлж ирсэн билээ. Олон дорвитой бүтээл, түүний дотор В.Хайссигийн “Монголын уран зохиолын түүх”-ийн 2 дэвтэр (1972), “Өвөр Монголын Олон сүмээс олдсон Монгол гар бичмэлийн үлдэгдэл (16-17 зуун) (1976) гэх мэт монгол судлалын холбогдолтой бүтээл хэвлэгджээ. Герман улсад Төв Ази, түүний дотор монгол судлалд томоохон хувь нэмэр оруулсан эрдэмтдийн тухай өгүүлбэ. Үүнд:

- Доктор, профессор Эрих Хэниш (Prof.Erich Haenisch) (1880-1966) бол Германы нэрт дорнодахин судлаач юм. Тэрээр 1925 оноос Геттинген, Лейпциг, Берлин, Мюнхен хотын их сургуульд профессор багшаар 1951 он хүртэл ажиллажээ. Тэрбээр дорнодахин, хятад, монгол судлалын чиглэлээр судалгаагаа явуулжээ. Монгол судлалд их зүйл бүтээсэн бөгөөд Саган сэцэний “Эрдэнийн товч”, “Алтангэрэл”,

“Ил хаадын бичиг”, “Хятад, Монголын харилцааны бичиг”, “Нууц товчоо”-ны галиг, орчуулга, толь бичиг зэргээс тодорхой юм. Мөн Дорнод Туркестан судлалаар А. Фон Ле Кок: Дорнод Туркестанд Хелласын мөрөөр, Германы Турфаны шинжилгээний 2, 3-р ангийн мэдээ болон адал явдал” (шүүмж), “Берлиний Турфаны цуглуулгын монгол хэлээрх зүйлс” гэх мэт нийтдээ 60 ном, эрдэм шинжилгээний өгүүлэл, шүүмж зэргийг хэвлүүлсэн ажээ.⁴⁸

- Доктор, профессор Вальтер Хайссиг (Prof. Walter Heissig) (1913-), бол Германы нэрт дорнодахин, монгол судлаач юм.⁴⁹ Олон Улсын Алтай Судлалын Байнгийн Бага Хурлыг (PIAC) үндэслэн байгуулагч, анхны ерөнхий нарийн бичгийн дарга нь юм. Профессор Хайссиг бол монголын аман зохиол, уран зохиол, угсаатны зүй, шашин, дундад эртний бичгийн дурсгал, ном зүйн судлал болон Төв Азийн судлалаар арвин баялаг бүтээл туурвисан эрдэмтдийн нэг билээ. 1991-2000 оны хооронд Төв Азийн судлалын нэрт эрдэмтний бүтээлийн тоо 275 болсон бөгөөд тэдгээр нь судалгааны ном, эрдэм шинжилгээний өгүүлэл, шүүмж зэргээс бүрдсэн байна. Мөн профессор В.Хайссиг нь “Готтингений Азийн судлал”, (1954-1958) 10 дугаар, “Азийн судлал” (88 дугаар), “Monumente Linguarm Asie Maiors” (3 дэвтэр) “Бонны их сургуулийн Төв Азийн хэл, соёл, судлалын семинарын Төв Азийн судлал” (2000 хүртэл 30 дугаар) зэрэг цувралыг эрхлэн гаргаж байжээ.

- Доктор, профессор Ёоханнес Шуберт (Dr.Prof.Johannes Schubert) (1896-), германы нэрт хятад, түрэг, төвд, монгол, манж судлаач юм. Мөн эдгээр хэлийг их сургуульд зааж байсан сурган хүмүүжүүлэгч билээ. Түүний бүтээлийн жагсаалтад нь монгол судлалын асуудлаар туурвисан 15 бүтээл бүртгэгдсэний дотор 1961 онд хэвлэгдсэн “Монгол-Герман толь” байна.⁵⁰

- Доктор профессор Бертольд Шпулер (Prof. Bertold Spuler) (1911) бол Германы нэрт дорнодахин судлаач юм. Тэрээр Геттинген, Мюнхен, Хамбургийн их сургуульд хичээл зааж Анкара, Константинополь, Бордоу, Лос Анжелос, Кабулын их сургуульд зочин профессороор ажиллаж байжээ. Түүний монгол судлалаар туурвисан бүтээлийн цэсэд ердөө 9 байх боловч түүнийг “Иран дахь монголчууд: 1220-1350 оны ил хаадын үеийн улс төр захиргаа хийгээд соёл”, “Монголчуудын түүх 13, 14 дүгээр зууны үеийн дорнын болон европын баримт нотолгоонд тулгуурлан өгүүлэхэд” хэмээх номууд нь шинжлэх ухааны томоохон бүтээлийн хувьд алдаршсан юм.⁵¹

- Доктор, профессор Клаус Загастер (Prof.Sagester Klaus) - (1933 оны 3р сарын 19-нд төрсөн), Германы нэрт монголч эрдэмтдийн нэг юм. 1970 оноос Бонн хотын их сургуулийн Төв Азийн хэл соёл судлалын семинарын профессор болж 1982-1990 оны хооронд тус

семинарын анхны захирал профессор В.Хайссигийн халааг авч ажиллаж байлаа. Тэрээр монголын уран зохиол оюуны соёлын түүхийн асуудлаар их зүйл хийжээ. Профессор Клаус Загастерийн бүтээлийн жагсаалтад 52 зүйл оржээ.⁵²

- Доктор, профессор Михаэл Вайэрс (Prof. Michael Weiers) (1937 онд төрсөн) Германы нэрт Төв Ази монголч эрдэмтэн юм. Тэрбээр Алтай судлал, Төв Ази судлал, исламын судлалаар их зүйл бүтээжээ. Тэрээр 1972 оноос Бонний их сургуулийн дэргэдэх Төв Азийн хэлд соёл судлалын профессор, 1991 оноос тус семинарын захирал байв. Тэрбээр төгс мэдлэгтэй монгол, манж, төвд, хятад, араб, эстон, перс, самгарди, өрнөд европын бүх үндсэн хэлийг сайн мэддэг хүн юм.⁵³

- Доктор, профессор Герхард Дөрфер профессор (Prof. Herhard Dürfer 1920-) бол Германы нэрт алтай судлаач юм. 1954 онд Берлиний чөлөөт их сургуульд “Монголын нууц товчооны өгүүлбэр зүйн тухай” сэдвээр дэд докторын зэрэг хамгаалсан байна. Тэрээр алтайн хэл шинжлэл түүний дотор монгол хэлний судлалаар судалгааны бүтээлүүд туурвисан байна. Судалгааны шүүмжийн дотор “Кришнер Марк “Казах хэлний авиа судлал” орсон байна. Герхард Дөрферийн 1955-1994 он хүртэлх бүтээлийн жагсаалтад 43 ном эрдэм шинжилгээний өгүүлэл шүүмж оржээ.⁵⁴

- Доктор, Херберт Франке (von Herbert Franke) Германы хятад, монгол судлаач дэлхийд нэрд гарсан эрдэмтэн билээ. Хятад, Дотоод Азийн түүх, хууль эрх, соёлын судлаач мэргэжилтэн юм. Г.Франке олон тооны ном өгүүлэл тулгуур бүтээлүүдийг бичсэн бөгөөд зөвхөн монгол судлалаар гэхэд 39 тэмдэглэгдсэн байна. Түүний судалгааны хүрээ маш өргөн бөгөөд монгол, манж, төвд, хятад, түрэг, араб, иран, смит судлал, хэл шашин судлалыг хамарч байна. Түүний 1966-2000 оны хооронд туурвисан бүтээлийн бүрэн жагсаалтад 238 ном, зохиол байна.⁵⁵

- Доктор, профессор Вероника Файт (Prof. Veronika Veit) нь нэрт монголч эрдэмтэн юм. Бонны их сургуулийн Төв Азийн хэл, соёл судлалын семинарт суралцан төгссөн тэндээ багшилж байгаа эрдэмтэн юм.⁵⁶ Түүний эрдэм шинжилгээний сонирхолын хүрээ нь 1644-1911, 1911-1921 оны Монголын түүхийн асуудал бөгөөд энэ асуудлаар 60-аад бүтээл туурвисан байна.

- Доктор Рудольф Кашевский (Rudolf Kashewsky 1939 онд төрсөн) монгол, манж, буддын судлаач юм. Ялангуяа Төв Азийн улс түмний туульсийн зохиолыг судалжээ.⁵⁷

- Доктор, профессор Ханс-Петер Фийце (von Hans-Peter Vietze) бол нэрт монголч, алтай хэл шинжлэлийн эрдэмтэн юм. Түүний бичсэн судалгааны бүтээлийн жагсаалтанд 69 ном, өгүүлэл, шүүмж оржээ.⁵⁸

- Доктор, профессор Удо Баркманн (Barkmann Udo. B) МУИС-ийг монгол судлал, түүх, манж судлалаар төгссөн, авъяаслаг монгол

судлалтан юм. Түүний бүтээлийн жагсаалтанд монгол судлалын асуудлаар туурвисан 67 ном, өгүүлэл тусгагдсан байна.⁵⁹

- Доктор Ута Шёне (төрсөн нэр нь Реттих Uta Schöne Rettich) бол мэргэжлийн монгол судлаач, авъяаслаг эрдэмтэн, сурган хүмүүжүүлэгч билээ. Тэрбээр монгол судлалын асуудлаар 27 судалгааны ном, өгүүлэл бичиж хэвлүүлсэн байна.⁶⁰

- Доктор Клаус Коппе (Klaus Koppe) бол мэргэжлийн монгол судлаач, авъяаслаг эрдэмтэн юм. Түүний сонирхол нь монголын туульс, толь зүй юм.⁶¹ Мөн тэрчлэн доктор Юрген Барковский (Jürgen Barkowski),⁶² доктор Ренате Бауве-Радна (Renate Bauwe-Radna),⁶³ доктор Клаус-Дийтер Барманн (Klaus-Dieter Bormann),⁶⁴ доктор Ренате Барманн (Renate Bormann),⁶⁵ доктор Елизабет Чиодо (Shiodo Elisabete),⁶⁶ Доктор, профессор Ханс-Райнер Кэмфе (Prof. Kampfe, Hans-Rainer)⁶⁷ бол дорнодахин, алтай хэл шинжлэлийн нэрт эрдэмтэн, доктор Шилиембүүгийн Рашидондог (1911-1998),⁶⁸ доктор, професор Паул Рангевски (Paul Ratschnewsky),⁶⁹ доктор Эрика Таубе (Erika Taube),⁷⁰ доктор Манфред Таубе (Manfred Taube),⁷¹ Петер Финке /Peter Finke/⁷² зэрэг монгол судлал, Төв Ази, алтай хэл шинжлэлийн талаар судалсан нөр их хөдөлмөр, эрдмийн ажил нь Германы монгол судлал, Төв Ази судлалын сор болсон бүтээлүүд билээ.

Монгол Улс, ХБНГУ-ын Ерөнхийлөгч нарын ивээл дор эГерманы археологийн институт (KAVA), Бонны Их сургуультай хамтарсан “Хархорум” төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд тус төслийн хүрээнд 2005 онд Өгөөдэй хааны хэмээх ордны туурийг үргэлжлүүлэн малтаж, 64 баганы чулуун сууриас байрандаа үлдэж хоцорсон сууриуд, эдгээрийн дунд байсан ногоон паалантай шалны хэсгүүдийг илрүүлэн гаргажээ. Уг ордны шалан дээр их хэмжээтэй овоорсон шавар бурхан болоод цацны хэсгүүд, бурхны сэнтий зэрэг олон тооны олдвор илрүүлэн олсон байв. Өмнөх жилүүдэд малталт хийж байсан талбайн зарим өргүүдийг үргэлжлүүлэн малтаж, барилгын элдэв чимэглэл, хэрэглэгдэхүүн илрүүлэн олсон ба ордны зохион байгуулалттай холбоотой сонирхолтой тоосгон өрлөгүүд, дагтаршуулсан шороон суурийн хязгаарыг олж гаргажээ. Германы талаас Археологийн хүрээлэнгийн ерөнхий ба харьцуулсан археологийн комиссын археологич, доктор, профессор Х.Г.Хүттел, археологич К.Франкен, ХБНГУ-ын Бонны Их Сургуулийн Эртний түүхийн хүрээлэнгийн доктор Э.Пүүл, археологич Х. Кельценберг нарын 21 судлаачид оролцон ажиллажээ.

2006 онд Хархорумын туурийн дэвсгэр нутагт нийт 5 хэсэг газарт геосоронзон, геодезийн хайгуул, зураглал, малтлага судалгаа хийжээ. 2007 онд Хархорумын туурийн археологийн малталт судалгааг өргөжүүлэн, уг төслийг Монгол-Германы “Орхон” Экспедици болгон

өргөтгөж, шинэчлэн зохион байгуулах хэлэлцээрт гарын үсэг зурсан байна. Тус шинжилгээний ангийн бүрэлдэхүүн Хархорумын их хэрмийн хойд хэсэгт орших гадуураа тусгай хэрэм бүхий барилгын суурийг үргэлжлүүлэн судалсан байна. Монгол-Германы “Орхон” төслийн хийж гүйцэтгэж буй өөр нэг шинэлэг шинжилгээ нь Архангай аймгийн Хотонт сумын нутагт орших, Хөх Түрэгийн Нэгдсэн хаант улсын нийслэл хот байсан Орда балгасыг агаараас тандан судлаж, орчин үеийн гурван хэмжээст лазерын скайн зураглал хийжээ. Германы Археологийн хүрээлэнгийн ерөнхий ба харьцуулсан археологийн комиссын археологич, доктор, профессор Х.Г.Хүттел, археологич К.Франкен нарын судлаачид оролцон ажилласан байна.

2008 онд “Орхон” төслийн хүрээнд Орда балгасын топографийн хэмжилт, хотын нарийвчилсан дэвсгэр зургийг боловсруулах зэрэг ажлыг үргэлжлүүлэн хийжээ. Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг Орхон голын баруун эрэгт санамсаргүй байдлаар барилга байгууламжийг чимэглэх гар урчуудын нэгэн суушын үлдэгдэл, барилгын тоосго, дээврийн ваар үйлдвэрлэж байсан гэрч баримт болох бамбай мэт хэлбэртэй зэрэгцэж байрласан гурван ижилхэн зуух, түүнчлэн барилгын чимэглэл шатаах, будаж пааландах зэрэг илүү нарийн үйлдвэрлэл явуулж байсны ул мөрийг хадгалсан дүгэрэг хэлбэртэй нэг зуух, нийт 4 зуух олдсон байна.

Дээр өгүүлснээс үзэхэд, Герман улсад монгол судлал хожуухан эхэлсэн боловч эрчимтэй хөгжсөн нь харагдаж байна. Мөн Герман улсад монгол судлалын өөрийнх нь хөгжлийн талаарх У.Баркманн, Д.Цэрэнсодном, В.Файт болон Оросын эрдэмтэн М.И.Гольманы “Өрнөдийн монгол судлал” хэмээх бүтээлд төв, судлаач, нийгэмлэгийн талаар тодорхой өгүүлсэн бол С.Алимаа, Г.Лувсан нар “Германы монголч эрдэмтдийн товч намтар, бүтээлийн жагсаалтыг нийтлүүлсэн байна. Ф.Файт, У.Баркманн нарын сэдэвчилсэн бүтээлээс үзэхэд 1996 он хүртэл монгол судлалаар Германы эрдэмтдийн бичсэн 765 бүтээлийн нэрс нийтлэгдсэн байна. 2002 онд С.Алимаа, Г.Лувсан нарын номонд монгол судлаач 35 эрдэмтний бүтээлийн жагсаалтыг нийтэлжээ. Үүнээс үзэхэд өнгөрсөн 100 гаруй жилийн дотор Германд Монголыг судалдаг эрдэмтэд төдий л олон биш байсан боловч гаргасан бүтээл нь арвин их бөгөөд эрдэм шинжилгээний өндөр түвшинд бичигдсэн нь тодорхой байна. Эрдэмтдийн гаргасан бүтээлийн тоо харилцан адилгүй зарим нь олон, зарим нь цөөн бүтээл хэвлүүлсэн хэдий ч судалгаа бүр өөрсдийн өвөрмөц онцлогтой, салбар шинжлэх ухаанд тодорхой байр суурийг эзэлж байна.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

33. A.Gr̃nwedel Altbuddhistische Kultst̃tten in Chinesisch-Turkistan (Berlin 1912) s.223,313
34. A.Le Coq Т̃rkische Manich̃ica aus Chotscho, Bd.1-3.Berlin 1912-1922.s.113-118
35. Turfanforschung Berlin-Brandenburgische Akademie der Wissenschaften.2002 <http://www.bbaw.de/vh/turfan/index.html>
36. E.Trinkler, Im Land der St̃rme mit Par und Kamelkarawanen durch Innersaien, Leipzig 1930. Die Zentralasien-Expeditio 1927-1928. Geographie und arch̃ologische Ergebnisse-Deutsche Forschung, H.B. 1930.
37. G.Gropp, Arch̃ologische Funde aus Lehoten-Chinesisch Ostturkistan, Die Trinkler Sammlung im Ubersee-Museum Bremen 1994.
38. J.Marquart, Die Chronologie der altturkischen Inschriften, L.,1898.Die Sogdiana des Ptolemaios, vol 15.,1946.
39. A.v.Gabain,Historisches aus den Turfan-Handschriften-AO,Vol.32,1970 Zentralasiatische t̃rkische Literaturen, Hor.Vol..1963.
40. F.W.K.M̃ller, Ein Doppelblatt aus einem manich̃ischen Hymnenbach –APAW 1912-1913.Handschriften-Reste in Estrangelo-Schrift aus Turfan, Chinesisch Turkestan, Bd.1.SPAW,Bd.2.1904.
41. J.Benzig. Das Hunnische, Donaubulgarische und Wolgabulgarische Sprachreste-Ph TF. 1959.s.685-695. Einf̃hrung in das Studium der altasiatischen Philologie und der Turkologie, Wiesbaden 1953.
42. G. Doerfer, Zur Sprache der Hunnen, Central Asiatic Journal /1973/, s.1-50.
43. Mark Kirchner” The language of the Kazaks from Xinjiang: a Text sample”. s-189-201- Thomas Hippe. “Kazak Pastoralism in the Bogda Range.” s.201-241.” The Kazaks of China Essays on an Ethnic Minority”. Uppsala-1988.
44. С.Алимаа, Т.Лувсан Германы монголч эрдэмтэдийн товч намтар, бүтээлийн жагсаалт УБ.2002 153-155.
45. С.Алимаа, Т.Лувсан Германы монголч эрдэмтэдийн товч намтар, бүтээлийн жагсаалт УБ.2002 58.
46. С.Алимаа, Т.Лувсан Германы монголч эрдэмтэдийн товч намтар, бүтээлийн жагсаалт УБ.2002 s.125-130.

47. С.Алимаа, Т.Лувсан Германы монголч эрдэмтэдийн товч намтар, бүтээлийн жагсаалт УБ.2002 s.181-186.
48. С.Алимаа, Т.Лувсан Германы монголч эрдэмтэдийн товч намтар, бүтээлийн жагсаалт УБ.2002 60-71. М.И.Гольман Өрнөдийн Монгол судлал. (Төв, судлаач, нийгэмлэг), ХХ зууны 50-аад оноос 90-ээд оны эхэн. УБ. 2005 28-30.
49. С.Алимаа, Т.Лувсан Германы монголч эрдэмтэдийн товч намтар, бүтээлийн жагсаалт УБ.2002 s.71-114. М.И.Гольман Өрнөдийн Монгол судлал. (Төв, судлаач, нийгэмлэг), ХХ зууны 50-аад оноос 90-ээд оны эхэн. УБ. 2005.s.117-118
50. С.Алимаа, Т.Лувсан Германы монголч эрдэмтэдийн товч намтар, бүтээлийн жагсаалт УБ. 2002 s.161-164
51. М.И.Гольман Өрнөдийн Монгол судлал. (Төв, судлаач, нийгэмлэг), ХХ зууны 50-аад оноос 90-ээд оны эхэн. УБ. 2005.s.88-89 Алимаа, Т.Лувсан Германы монголч эрдэмтэдийн товч намтар, бүтээлийн жагсаалт УБ.2002 s.165-166
52. С.Алимаа, Т.Лувсан Германы монголч эрдэмтэдийн товч намтар, бүтээлийн жагсаалт УБ.2002 s.143-152
53. М.И.Гольман Өрнөдийн Монгол судлал. (Төв, судлаач, нийгэмлэг), ХХ зууны 50-аад оноос 90-ээд оны эхэн. УБ. 2005.s.89-91 Алимаа, Т.Лувсан Германы монголч эрдэмтэдийн товч намтар, бүтээлийн жагсаалт УБ.2002 s.208-237
54. С.Алимаа, Т.Лувсан Германы монголч эрдэмтэдийн товч намтар, бүтээлийн жагсаалт УБ.2002 s.41-47
55. С.Алимаа, Т.Лувсан Германы монголч эрдэмтэдийн товч намтар, бүтээлийн жагсаалт УБ.2002 s.48-55
56. М.И.Гольман Өрнөдийн Монгол судлал. (Төв, судлаач, нийгэмлэг), ХХ зууны 50-аад оноос 90-ээд оны эхэн. УБ. 2005.s.91-92 Алимаа, Т.Лувсан Германы монголч эрдэмтэдийн товч намтар, бүтээлийн жагсаалт УБ.2002 s.187-197
57. М.И.Гольман Өрнөдийн Монгол судлал. (Төв, судлаач, нийгэмлэг), ХХ зууны 50-аад оноос 90-ээд оны эхэн. УБ. 2005.s.92-93 Алимаа, Т.Лувсан Германы монголч эрдэмтэдийн товч намтар, бүтээлийн жагсаалт УБ.2002 s.120-122
58. С.Алимаа, Т.Лувсан Германы монголч эрдэмтэдийн товч намтар, бүтээлийн жагсаалт УБ.2002 s.198-207
59. С.Алимаа, Т.Лувсан Германы монголч эрдэмтэдийн товч намтар, бүтээлийн жагсаалт УБ.2002 s.15-26
60. мөн тэнд.т.156-160
61. мөн тэнд.т.123-124

62. мөн тэнд.т.27
63. мөн тэнд.т.28-32
64. мөн тэнд.т.33-34
65. мөн тэнд.т.35-37
66. мөн тэнд.т.38-40
67. мөн тэнд.т.116-119
68. мөн тэнд.т.133-135
69. мөн тэнд.т.136-142
70. мөн тэнд.т.167-176
71. мөн тэнд.т.177-180
72. Peter Finke Kazak Pastoralists in Western Mongolia. Economic and Social Change in the Course of Privatization. In: *Nomadic Peoples* 36/37: 195-216. The Kazaks of Western Mongolia. In: Ingvar Svanberg (ed.) *Contemporary Kazaks. Cultural and Social Perspectives*. London: Curzon: 103-139(with Sarah Robinson & Bettina Hamann) The impacts of de-collectivisation on Kazak pastoralists. Case studies from Kazakstan, Mongolia, and the People's Republic of China. In: *Journal of Central Asian Studies* Vol. IV, No. 2: 2-33. *Nomaden im Transformationsprozess. Kasachen in der post-sozialistischen Mongolei*. Münster: Lit-Verlag.